



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/318

Алтай хот


Автомашингүй өдөр болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр буюу 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг автомашингүй өдөр болгосугай.

2.Автомашингүй өдрийг зохион байгуулж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

0201061028